



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/122

Номгон

Хүүхдийн эрхийг хамгаалах зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29- ний өдрийн "Хүүхдийн эрхийг хамгаалах зарим арга хэмжээний тухай" 41 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/122 дугаар тушаалаар баталсан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын 2.1, 14.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морь, тэмээний уралдаан, бооцоот уралдаан, үсэргээ, сунгаанд 18 хүртэлх насны хүүхдээр унуулахыг хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах, заагдсан хугацаанд хурдан морь, тэмээний уралдаан, бооцоот уралдаан, үсэргээ, сунгаанд 18 хүртэлх насны хүүхдээр унуулсан иргэн, зохион байгуулагч талыг Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцож ажиллахыг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хошууч Т.Цэвээндорж), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга (Хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч Н.Мэндбаяр), сумдын Засаг дарга нарт (Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн) тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн "Өвөл, хаврын хурдан морины уралдааныг хориглох тухай" А/79 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.ЭНХБАТ



626010029

D:\2026\1.Zakhiramj\Zakhiramj 1.docx



دستور مصنف: [نام دست‌نویس]
تاریخ تصویب: [تاریخ]

R		₹
O		
R		₹
O		
B		₹

6

தமிழ்

لەمبار و مەسەن
لەمبار و مەسەن

[illegible][illegible][illegible]

فوق محنتیں ہیں ..

Omavilj



642501755